



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 1/268

Номгон

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний
хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 44 дүгээр зарлиг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 17.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


- 1.“Тэрбум мод таны тарьсан нэг модноос эхэлнэ” уриалга дор аймгийн хэмжээнд 2026 оны хаврын улиралд мод тарих ажлыг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.
- 2.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Мод тарьж ургуулах арга хэмжээг батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны газар (Б.Бат-Өлзий), бүх сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.
- 4.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд өрх бүр хашаандаа 5-аас доошгүй мод тарьж ургуулахыг уриалж, аж ахуйн нэгж, байгууллагууд өөрийн эзэмшлийн газрын 10 хувиас доошгүй талбайд мод тарьж, ногоон байгууламж байгуулах, уг нөхцөлийг хангах боломжгүй тохиолдолд сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагын орчим болон Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газраас хуваарилсан талбайд дүйцүүлэн мод тарих ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэхийг аж ахуйн нэгж байгууллага, байгууллагын дарга, эрхлэгч, захирал, иргэдэд үүрэг болгосугай.
- 5.Мод, тарьц суулгац ургуулах арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж тайлан, тоон мэдээг 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн дотор Байгаль орчны газарт ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт, 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт хүргүүлэхийг Байгаль орчны газар (Б.Бат-Өлзий)-т тус тус үүрэг болгосугай.

626010727

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр)-т даалгасугай.



Аймгийн Засаг даргын Тамгын Газар 45 дугаар
сарын 01-ний өдөр 2026.05.20 дугаар
захирамжийн хавсралт



**“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД 2026 ОНЫ
ХАВРЫН УЛИРАЛД МОД ТАРИХ, АРЧЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэгч
1	2	3	4	5
1	Мод тарих талбай, бууц, бор шороо бэлтгэх, тарьсан мод услах худаг, ус, хашаа хамгаалалтын асуудлыг бүрэн шийдвэрлэж мод тарих ажлын бэлтгэлийг хангах.	2026.04.20 2026.05.10	Сумдын Засаг дарга нар	-
2	Мод тарих ажлыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх.	2026.04.20 2026.05.25	БОГ, Сум дундын ойн анги	Сумдын Засаг даргын Тамгын газар, Номгон телевиз
3	Тарьц, суулгацын үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, мод тарих аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг стандартын тарьц, суулгацаар хангаж, технологийн заавар, зөвлөмж өгөх, тарьц, суулгацын гарал үүсэлд хяналт тавьж ажиллах.	2026.05.08	БОГ, Сум дундын ойн анги, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	Сумдын Засаг даргын Тамгын газар, Мод үржүүлэг, ойжуулах, нөхөн сэргээх мэргэжлийн байгууллагууд, Уул уурхайн ААН.
4	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021 оны намрын улирлаас эхлэн таригдсан моддын өвөлжилтийн дараах тооллого, амьдралын хувийг тогтоох, нөхөн тарилтыг зохион байгуулах, тарьсан моддын усалгаа арчилгааг тарьсан байгууллага, ААН, иргэдийг оролцуулан гүйцэтгэх.	2026.04.25 2026.05.10	Сумдын Засаг дарга нар,	Иргэн, ААН, байгууллага
5	Бүх нийтээр мод тарих өдрүүдэд сумдын хэмжээнд төвлөрсөн байршлуудад мод тарих арга хэмжээг зохион байгуулах.	2026.05.01 2026.05.30	Бүх шатны Засаг дарга нар,	Иргэн, ААН, байгууллага
6	Төвлөрсөн байршилд мод тарих боломжгүй бол тухайн баг, хорооны бүх өрх, бүх шатны сургуулийн өмнөх боловсролын байгууллага эмнэлгийн орчинд мод тарих арга хэмжээг зохион байгуулах.	2026.05.01 2026.10.26	Сумдын Засаг дарга нар,	Бүх шатны эрүүл мэндийн төв, ерөнхий боловсролын сургуулиуд.

1	2	3	4	5
7	ААН, байгууллагууд өөрийн эзэмшлийн барилга, байгууламжийн газрын 10%-д ногоон байгууламж бий болгох ажлыг зохион байгуулах.	2026.05.01 2026.05.30	Сумдын Засаг дарга нар,	Бүх шатны ААН, байгууллага.
8	Мод тарих үйл ажиллагаанд дуслын усалгааны систем өргөнөөр нэвтрүүлэх зэрэг усалгааны хэмнэлттэй технологи нэвтрүүлэх.	2026.05.01 2026.05.30	Сумдын Засаг дарга нар,	ААН, байгууллага
9	Арго ойн аж ахуйг хөгжүүлэх ажилд орон нутгийн иргэдийг татан оролцуулан, хамтарч ажиллах.	2026.05.01 2026.05.30	Бүх шатны Засаг дарга нар,	БОГ, сум дундын ойн анги
10	Тарьсан мод бүрийг бүртгэж, усалгаа, арчилгааг хариуцах эзэнтэй болгох, <u>terbummod</u> гар, утасны аппликэшнд бүртгүүлэх.	2025.10.02 2025.10.30	Сумдын Засаг дарга нар	-
11	Мод тарих арга хэмжээнд нэгдсэн иргэн, ААН, байгууллагын тайлан, мэдээг нэгтгэн хүргүүлэх.	2026.06.05	Сумдын Засаг дарга нар	-
12	Сумдаас ирүүлсэн тайлан, тоон мэдээг нэгтгэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт хүргүүлэх.	2026.06.10	Байгаль орчны газар	-